



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 19 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 19 дүгээр хуралдааныг 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулав.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 19 дүгээр хуралдаанаар /2025-09-18/ “Харилцаа холбооны зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн 2025 оны эхний хагас жилийн үндсэн статистик үзүүлэлтүүд”-ийн танилцуулга; Харилцаа холбооны зохицуулах хороонд 2025 оны эхний хагас жилд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлангийн танилцуулга болон шүүхийн гомдол маргааны талаар мэдээлэл; Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтийн тухай (ХХЗХ-ны 2025 оны 151, 152, 153, 154, 155 тоот тогтоолыг хэрэгжүүлэх); “ХХЗХ-ны үйл ажиллагааны дунд хугацааны стратеги: 2022-2025 он”-ийн хэрэгжилтийн үнэлгээний /тайлан/-гийн танилцуулга; ХХЗХ-ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар танилцуулга /эхний хагас жилийн эцсийн байдлаар/; Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Согно Телеком ХХК-д шалгалт хийсэн ажлын хэсгийн тайлан, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай санал дүгнэлтийн тухай; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлт) асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 18 (Тогтоол №192-209, 2025-09-18) тогтоолыг тус тус батлан шийдвэрлэв.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 19 дүгээр хуралдаанаар “Харилцаа холбооны зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн 2025 оны эхний хагас жилийн үндсэн статистик үзүүлэлтүүд”-ийн танилцуулга; Харилцаа холбооны зохицуулах хороонд 2025 оны эхний хагас жилд ирүүлсэн өргөдөл, гомдлын барагдуулалт, шийдвэрлэлтийн тайлангийн танилцуулга болон шүүхийн маргааны талаар мэдээллийг тус тус сонсож, хэлэлцсэн асуудлаар холбогдох удирдамж чиглэлийг хариуцсан ажлын алба, бүтцийн нэгжид үүрэг болгон улирал, хагас жилээр хорооны хуралдаанд тухай бүр танилцуулж ажиллахыг даалгав.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.9 дэх заалтыг үндэслэн баталсан зохицуулах хорооны 2025 оны ээлжит 12 дугаар хуралдааны /2025-05-29/ 115 тоот тогтоолоор ХХЗХ-ноос 2025 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог баталсан юм. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор тус хорооны 2025 оны ээлжит 15 дугаар хуралдаанд /2025-07-08/ ӨНЗГ, ЗЗҮТЗГ, ЗУХАГ, Хуулийн хэлтэс хамтран “Нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай” багц 5 сонгон шалгаруулалтын баримт бичгийн төсөл, баримт бичгийн төслийн агуулга, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах хугацааны хуваарийн төсөл, дэлгэрэнгүй танилцуулга, зах зээлийн судалгаа, хууль эрх зүйн үндэслэл, тооцоо судалгаа, тогтоолын төслийг тус тус боловсруулан хэлэлцүүлж,

2025 оны 151, 152, 153, 154, 155 тоот (Монгол Улсад арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай; Улаанбаатар хотод арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай; Увс аймагт Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай; Дундговь, Говьсүмбэр аймагт арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай; Орон нутагт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай) тогтоолыг тус тус батлуулсан билээ. ХХЗХ-ноос 2025 оны 151, 152, 153, 154, 155 тоот тогтоолуудыг (Нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай) хэрэгжүүлэх зорилгоор Хорооны даргын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн тушаалаар холбогдох 5 сонгон шалгаруулалт тус бүрийн үнэлгээний ажлын хэсэг байгуулсан ба уг үнэлгээний ажлын хэсгээс дараах 5 сонгон шалгаруулалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрөөс 60 хоногийн хугацаатай тус тус зарлан байгууллагын цахим хуудасны мэдээ, мэдээлэл хэсэгт урилга байршуулсан (<https://crc.gov.mn/posts/songon-salgaruulaltyn-urilga>). Үүнд:

1. ХХЗХ-ноос тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор **АрТВ-Монгол Улс-2025** тоот “Монгол Улсын нутаг дэвсгэрт Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”;
2. ХХЗХ-ноос тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор **АрТВ-Улаанбаатар хот-2025** тоот “Улаанбаатар хотод Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”;
3. ХХЗХ-ноос тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор **ӨНТВ-Орон нутаг-2025** “Увс аймгийн нутаг дэвсгэрт Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”;
4. ХХЗХ-ноос тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор **АрТВ-Орон нутаг-2025** “Говьсүмбэр, Дундговь аймгийн нутаг дэвсгэрт Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”;
5. ХХЗХ-ноос тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор **АрР-Орон нутаг 2025** тоот “Орон нутагт Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл болон Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт” зэрэг болно.

Иймээс ХХЗХ-ны 2025 оны ээлжит 19 дүгээр хуралдаанаар дээрх 5 сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан Үнэлгээний ажлын хэсгийн зохион байгуулсан сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа, үнэлгээ гүйцэтгэсэн тайлан тэмдэглэл, холбогдох танилцуулга, үнэлгээний ажлын хэсгийн санал дүгнэлт болон “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” 4 тогтоолын төслийг тус тус авч хэлэлцэв. Тус хуралдаанаар 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” 4 тогтоолыг батлан шийдвэрлэв. Үүнд:

1. Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны “Нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоо батлах тухай” 2025 оны 115 дугаар тогтоол, Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай 2025 оны 151 дүгээр тогтоол, тус хорооны даргын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/182 тоот тушаалаар байгуулсан үнэлгээний ажлын

- хэсгийн 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 192 тоот “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг батлав. “Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтад, Тус хорооноос 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр зарласан “Монгол Улсын нутаг дэвсгэрт Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-д Монгол контент ХХК-ийг шалгарсанд тооцсугай. Тогтоолын 2 дугаар заалтад, Сонгон шалгаруулалтад шалгарсан Монгол контент ХХК-д Монгол Улсын нутаг дэвсгэрт арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 2030 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгосугай. Тогтоолын 3 дугаар заалтад, Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай. Тогтоолын 4 дүгээр заалтад, Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.
2. Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны “Нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоо батлах тухай” 2025 оны 115 дугаар тогтоол, Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай 2025 оны 151 дүгээр тогтоол, тус хорооны даргын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/182 тоот тушаалаар байгуулсан үнэлгээний ажлын хэсгийн 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 193 тоот “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг батлав. “Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтад, Тус хорооноос 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр зарласан “Монгол Улсын нутаг дэвсгэрт Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-д Плэймакс Анимүүд ХХК-ийг шалгарсанд тооцсугай. Тогтоолын 2 дугаар заалтад, Сонгон шалгаруулалтад шалгарсан Плэймакс Анимүүд ХХК-д Монгол Улсын нутаг дэвсгэрт арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 2030 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгосугай. Тогтоолын 3 дугаар заалтад, Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай. Тогтоолын 4 дүгээр заалтад, Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.
3. Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны “Нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоо батлах тухай” 2025 оны 115 дугаар тогтоол, Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай 2025 оны 151 дүгээр тогтоол, тус хорооны даргын 2025 оны 07 дугаар

сарын 08-ны өдрийн А/182 тоот тушаалаар байгуулсан үнэлгээний ажлын хэсгийн 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 194 тоот “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг батлав. “Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтад, Тус хорооноос 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр зарласан “Монгол Улсын нутаг дэвсгэрт Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-д Хөтөч чиглэл суваг ХХК-ийг шалгарсанд тооцсугай. Тогтоолын 2 дугаар заалтад, Сонгон шалгаруулалтад шалгарсан Хөтөч чиглэл суваг ХХК-д Монгол Улсын нутаг дэвсгэрт арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 2030 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгосугай. Тогтоолын 3 дугаар заалтад, Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай. Тогтоолын 4 дүгээр заалтад, Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.

4. Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны “Нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоо батлах тухай” 2025 оны 115 дугаар тогтоол, Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай 2025 оны 153 дугаар тогтоол, тус хорооны даргын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/181 тоот тушаалаар байгуулсан үнэлгээний ажлын хэсгийн 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 195 тоот “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож, тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг батлав. “Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтад, Тус хорооноос 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр зарласан “Увс аймгийн нутаг дэвсгэрт Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-д МБСТВ ХХК-ийг шалгарсанд тооцсугай. Тогтоолын 2 дугаар заалтад, Сонгон шалгаруулалтад шалгарсан МБСТВ ХХК-д Увс аймгийн нутаг дэвсгэрт Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 2030 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгосугай. Тогтоолын 3 дугаар заалтад, Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай. Тогтоолын 4 дүгээр заалтад, Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.

Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд Үнэлгээний ажлын хэсгээс 5 нээлттэй сонгон шалгаруулалтыг 60 хоногийн хугацаатай зарлан зохион байгуулахад “Улаанбаатар хотод Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”; “Говьсүмбэр, Дундговь аймгийн нутаг дэвсгэрт Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”; Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дундговь аймагт “Арилжааны

радиогийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл болон “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээд нараас санал, төсөл ирүүлээгүй талаар танилцуулав. Энэхүү асуудлаар нэр бүхий гишүүдээс дээр заасан 3 нээлттэй сонгон шалгаруулалтыг дахин зарлах, Хорооны 2025 оны 115 тоот квот тогтоосон тогтоолыг хэрэгжүүлэх шаардлагатай байгаа талаар гаргасан саналыг хэлэлцээд, материал ирүүлээгүй дээрх 3 сонгон шалгаруулалтыг дахин зарлаж сонгон шалгаруулалтын баримт бичгийг хавсралтаар батлах 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн “Сонгон шалгаруулалт дахин зохион байгуулах тухай” 3 тогтоолыг батлан шийдвэрлэсэн. Үүнд:

1. Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 10.12.1 дэх заалт, тус Хорооны 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 115 дугаар тогтоолыг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 206 тоот “Сонгон шалгаруулалт дахин зохион байгуулах тухай” тогтоолыг баталсан. “Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтад, “Улаанбаатар хотод Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр зарлаж, сонгон шалгаруулалтын баримт бичгийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай. Тогтоолын 2 дугаар заалтад, Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үнэлгээний ажлын хэсэг байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.
2. Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 10.12.1 дэх заалт, тус Хорооны 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 115 дугаар тогтоолыг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 207 тоот “Сонгон шалгаруулалт дахин зохион байгуулах тухай” тогтоолыг баталсан. “Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтад, “Говьсүмбэр, Дундговь аймгийн нутаг дэвсгэрт Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр зарлаж, сонгон шалгаруулалтын баримт бичгийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай. Тогтоолын 2 дугаар заалтад, Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үнэлгээний ажлын хэсэг байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.
3. Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 10.12.1 дэх заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.2, 5¹.1.11 дэх заалт, тус Хорооны 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 115 дугаар тогтоолыг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 208 тоот “Сонгон шалгаруулалт дахин зохион байгуулах тухай” тогтоолыг баталсан. “Энэхүү тогтоолын 1 дүгээр заалтад, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дундговь аймагт “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл болон “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрөл олгох нээлттэй сонгон шалгаруулалтыг 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр зарлаж, сонгон шалгаруулалтын баримт бичгийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай. Тогтоолын 2 дугаар заалтад, Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үнэлгээний ажлын хэсэг байгуулж,

тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 19 дүгээр хуралдаанаар хорооны нэр бүхий гишүүдийн 2025 оны ээлжит 15 болон ээлжит 17 дугаар хуралдааны үеэр гаргасан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Ажлын албаны даргын ахалсан мониторингийн ажлын хэсгээс боловсруулсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны үйл ажиллагааны дунд хугацааны стратеги: 2022-2025 он”-ийн хэрэгжилтийн үнэлгээний /тайлан/ танилцуулга; ХХЗХ-ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар танилцуулга /эхний хагас жилийн эцсийн байдлаар/-ыг тус тус сонсов. Хэлэлцсэн асуудлаар, энэхүү хуралдааны үеэр хорооны дарга, гишүүдээс байгууллагын дунд хугацааны шинэ стратегийн төсөл /2026-2029 он/, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах талаар өгсөн удирдамж чиглэлийг 2025 оны 12 дугаар сард багтаан Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхийг тэмдэглэлээр үүрэг болгож, ажлын хэсэг болон бүх газруудад тус тус өгөхөөр тогтов.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 19 дүгээр хуралдаанаар Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 6 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 6 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 196 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 3 хуулийн этгээдэд 3 тусгай зөвшөөрлийг (Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх-интернэт) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 197 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 4 хуулийн этгээдэд 4 тусгай зөвшөөрлийг (Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 198 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Бид мон корп ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс –АНУ/) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, , 5.5 дугаар зүйлийн 10, 14 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 199 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдийн 3 тусгай зөвшөөрлийг (Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар сунгасан;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10, 14 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 200 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг (МОНБЗ Продазшн ХХК: Дархан-Уул нутаг дэвсгэрт “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” 12800189 тоот тусгай зөвшөөрөл болон Дархан-Уул аймгийн Дархан сумын нутаг дэвсгэрт “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” 22800131 тоот тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10, 14 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 201 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Дабл линк дизайн ХХК: “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” 12100463 тоот тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.12.1, 14.12.2, 14.12.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 202 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Согно телеком ХХК: “Харилцаа холбооны сүлжээ байгуулах түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх” 16900002 тоот тусгай зөвшөөрлийг) 90 хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Эрчист гүрэн ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 203 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Эрчист гүрэн ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх” 43300019 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Мон ложистикс карго ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 204 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Мон ложистикс карго ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх” 43300026 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 205 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн (Албан журмын даатгагчдын холбоо ГҮТББ; Цагдаагийн ерөнхий газрын урьдчилан сэргийлэх алба) 2 харилцаа холбооны сүлжээний дугаарыг 2 жилийн хугацаагаар олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10, 14 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 209 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Скайстрим ХХК, 17000005 тоот: “Харилцаа холбооны

сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх /Хот, хот хооронд сүлжээ; Улс хоорондын сүлжээ; Улс хоорондын транзит урсгал дамжуулах/” тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар сунгаж тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг [энд дарж](#) үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-09-23